



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/166

Улаанбаатар хот

### Засгийн газрын үнэт цаасыг бүртгэлээс хасах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.3, "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 23 дугаар зүйлийн 23.1, 23.11.5 дахь заалтууд, "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 01/336 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын хөрөнгийн биржээр арилжигдсан Засгийн газраас гаргасан нэг бүр нь 100,000 (зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэтэй, хямдруулалттай, 40,000 (дөчин мянга) ширхэг, нийт 4.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 1324 кодтой, ЗГХБ-Б-26-502 нэртэй өрийн хэрэгслийн хугацаа дуусаж, төлбөр төлөгдсөн тул "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн үнэт цаасны бүртгэлээс хассугай.
2. Өрийн хэрэгслийг бүртгэлээс хассан тухай мэдэгдлийг "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" хязгаарлагдмал хариуцлагатай компанид хүргүүлэхийг Хяналт, зохицуулалтын газар (А.Мөнхбаясгалан)-т үүрэг болгосугай.
3. Өрийн хэрэгслийг бүртгэлээс хассан тухай мэдээллийг олон нийтэд хүргэхийг Бизнес хөгжлийн газар (Т.Хаш-Эрдэнэ)-т, цахим хуудас болон арилжааны системд холбогдох өөрчлөлт хийхийг Үйл ажиллагааны газар (И.Жавхлан)-т тус тус даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын мэргэжилтэн Ч.Эрдэнэболорт үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.МӨНХБАТ

1526030337

**ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН  
ХАДГАЛАМЖИЙН ТӨВ ХХК-д  
ХҮРГҮҮЛЭХ МЭДЭГДЭЛ №1324**

Хэнд: “Үнэт цаасны төвлөрсөн  
хадгаламжийн төв” ХХК-д

Огноо: 2026/04/07

ҮЗҮҮЛЭЛТ	ҮНЭТ ЦААС БҮРТГЭЛЭЭС ХАСАХ
<b>Мэдэгдлийн агуулга:</b>	Үнэт цаас хадгаламжаас хасах тухай
<b>Үндэслэл:</b>	“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2026.04.07 -ны өдрийн 9/16 тоот тушаал, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК -ийн 2026.04.02-ны өдрийн 01/336 тоот албан бичиг
<b>Санхүүгийн хэрэгсэл: /хувьцаа, өрийн хэрэгсэл гэх мэт/</b>	Засгийн газрын үнэт цаас
<b>Үнэт цаасны төрөл: /хямдруулалттай, купонтой/</b>	Хямдруулалттай
<b>Үнэт цаасны нэр:</b>	ЗГХБ-Б-26-502
<b>Үнэт цаасны код: /тоон код, ISIN/</b>	1324, MNZGKNB13240
<b>Үнэт цаасны хэлбэр: /биет, биет бус/</b>	Биет бус
<b>Нийт үнэт цаасны тоо: /ширхэг/</b>	40,000 ширхэг
<b>Үнэт цаасны нэрлэсэн үнэ: /төгрөг/</b>	100,000 төгрөг
<b>Үнэт цаасны нийт үнийн дүн: /төгрөг/</b>	4,000,000,000 төгрөг

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.МӨНХБАТ